



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 06 өдөр

Дугаар

A/681

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж батлах” 11/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын хөгжмийн зохиолчдын холбооны “Монгол улсын шилдэг дуунууд”, “Шилдгийн шилдэг хөгжмийн зохиолч шалгаруулах” “Морин хуур-2017” уралдаант наадмын тэргүүн гранпри шагналт, жил бүр зохион байгуулдаг “Алтан намар” наадмын 2018 оны Монголын хөгжмийн бүтээл шалгаруулах уралдааны шилдэг хөгжмийн зохиолч, тусгай байрын шагналт аймгийн “Төгөлдөр студи”-ийн захирал Базарсадын Хүрэлбаатарийн Монголын Улсын хөгжмийн зохиол, уран бүтээлийн салбарт гаргасан амжилт, орон нутагт соёл урлагийг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмэр, хөдөлмөрийн үр дүнг өндрөөр үнэлэн орон сууцны дэмжлэгт 30.0 сая төгрөг /гучин сая/-ийг олгосугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 30.0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 5.24-д баталсан “Чадварлаг Ховдчууд” хөтөлбөрийн арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ